

***Могойн гол ХК-ийн  
2021 оны үйл  
ажиллагааны  
тайлан***

# Уурхайн удирдлага, зохион байгуулалтын талаар

- Тайлант жилийн хугацаанд хувь нийлүүлэгчдийн хурал-1, ТУЗ-ийн хурал 3 удаа хуралдаж тухайн хурлуудаар 2021 оны үйлдвэрлэлийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалт, үйлдвэрийн түүхий эд материалыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж цаашдын ажилд чиглэл удирдлага болгон ажиллахаас гадна цаг үеийн асуудлаар холбогдох шийдвэрүүдийг гаргууллаа.
- 2021 онд захирлын 78 тушаал гаргаснаас боловсон хүчний холбогдолтой 62, үйл ажиллагааны холбогдолтой 16 тушаал тус тус гаргалаа. Дээд болон орон нутгийн байгууллагуудад 160 ширхэг албан бичиг явуулж шаардлагатай хариуг авснаас гадна төрийн болон орон нутгийн байгууллагаас ирсэн албан бичгийг холбогдох албан тушаалтанд өгч асуудлыг шийдвэрлэж хариуг хүргүүлэн ажиллалаа.
- Тайлант онд нийт 50 ажлын байранд 94 ажилтан ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 41 ажлын байранд 63 ажилтан тогтмол ажилласан байна. Шинээр байнгын болон түр ажлын байранд нийт 14 иргэнийг авч ажиллуулсан. Зарим ажлын байранд ажилчдыг эрх олгох болон мэргэшүүлэх сургалтанд бүрэн хамруулсан.

# Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар

- 2021 оны 3-р сарын 12-ны өдрөөс засвар үйлчилгээний ажлыг эхлүүлж 4-р сарын 12-ны өдрөөс хайгуулын 7-8-р огтлолын хооронд 1900-р түвшинд хюндай-520 экскаватораар хөрс хуулалтын ажлыг эхлүүлж ажилласан. ЭКГ-5А экскаваторын шаардлагатай сэлбэг материалыг дээрхи хугацаанд бэлтгэж засвар үйлчилгээг хийж 5-р сарын 12-аас 6-8-р огтлолын хооронд хөрс ачилтанд оруулан ажиллуулсан. Хөрс хуулалтын ажлыг ЭКГ-5А экскаватор дээр 12 цагаар 2 ээлж, Хюндай 520 экскаватор дээр мөн 12 цагаар 2 ээлжээр ажиллахаар зохион байгуулан нийт 6-7 автосамосвалыг ээлж тус бүр дээр хувиарлаж 1900-1860-р түвшинд 810.2 мянган м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил хийж гүйцэтгэн суналын дагуу 220 метр, дундаж зузаан 8,5 метр нийт 8150 м<sup>2</sup> талбай бүхий 90 мянган тн нүүрс олборлов.
- Өрөмдлөг тэсэлгээний ажлын тухайд 2 ээлжээр ажиллаж хөрсийг сийрэгжүүлсэн мөн бульдозерыг 2 ээлжээр ажиллуулж зам талбай овоолго түрэх ажлыг саадгүй ханган ажиллаж, хөрс хуулалтын ажлыг 4-р сараас 12-р сарын хооронд зохион байгуулж дуусгалаа.

# Хөрс хуулалтын ажлыг хийх үндсэн тоног төхөөрөмжүүд

## *Механизм*

- ЭКГ-5А экскаватор
- Хюндай 520 экскаватор
- САТ-320 экскаватор
- Өрмийн машин ЕСD-45Е
- Бульдозер SD-23

## *Тээвэр*

- Хово автосамосвал 2 ширхэг
- Белаз автосамосвал 1 ширхэг
- МТ86 автосамосвал 3 ширхэг

## Хөрс хуулалт нүүрс олборлолтын тоон үзүүлэлтийн талаар

| №  | Үзүүлэлт                           | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл | Гүйцэтгэлийн хувь, % |
|----|------------------------------------|--------------|-----------|----------------------|
| 1. | Хөрс хуулалтын ажил, мян.мкуб      | 1000.0       | 810.2     | 81%                  |
| 2. | Олборлосон нүүрсний хэмжээ, мян.тн | Эрчим хүчний | 110.0     | 90%                  |
|    |                                    | Коксжих      | 90.0      |                      |
| 3. | Борлуулсан нүүрсний хэмжээ, мян.тн | 115.0        | 100.0     | 87%                  |


## Тайланг онд хийж хэрэгжүүлсэн гол ажиллуудаас танилцуулбал

- Төлөвлөгөөт оны ажил эхлэхтэй холбогдуулан холбогдох яам, агентлагын газруудаар төлөвлөгөө тайланг 3-р сард багтаан баталгаажуулж ажиллаа.
- 4-р сард багтаан төлөвлөгөөт оны уулын ажил явуулах тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай сэлбэг материалын нөөцийг бэлтгэж их засвар үйлчилгээний ажлыг хийж ажилласан.
- 2021 оны худалдан авалтуудыг хууль журмын дагуу хийж гүйцэтгэж байна.
- Өдөр тутмын ажлыг тогмол хугацаанд наръяад даалгавараар ханган ажиллаж аль болох ажилчидыг ажлын цагт бүрэн ачаалалтай ажиллуулах тал дээр анхаарч ажиллалаа.




Төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэхэд шаардлагатай үйлдвэрийн гол түүхий эд болох түлш, шатахуун тосолгооны материал, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан, төлөвлөгөөний дагуу хууль журмын хүрээнд нээлттэй тендер зарлан шалгаруулж, 450.0 мянган литр дизель түлшийг 590.0 сая төгрөгөөр, 10.0 мянган литр бензинийг 8.0 сая төгрөгөөр, тос тосолгооны материал 55.5 сая төгрөгөөр, 303.9 тн тэсрэх материалыг 635.1 сая төгрөгөөр, тэсэлгээний хэрэгсэл 208.2 сая төгрөгөөр, 333.6 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 111.0 сая төгрөгийн хангамжийн материал худалдан авахаар төлөвлөж гүйцэтгэлээр дизель түлш 395.6 мянган литрийг 817.1 сая төгрөгөөр, бензин 13.7 мянган литрийг 26.3 сая төгрөгөөр, тос тосолгооны материал 19.3 сая төгрөгөөр тэсрэх материал 217.3 тн 414.8 сая төгрөгөөр, тэсэлгээний хэрэгслийг 108.3 төгрөгөөр сэлбэг хэрэгсэл 262.3 сая төгрөгөөр хангамжийн материал 59.0 сая төгрөгний худалдан авалт хийж ажилласан байна.

# Үйлдвэрийн гол түүхий эд материалуудын төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулсан үзүүлэлт





# Үйлдвэрийн гол түүхий эд материалуудын төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулсан үзүүлэлт



■ төлөвлөгөө/сая .төг/  
■ гүйцэтгэл /сая.төг/

дизель түлш

бензин

тос  
тосолгооны  
материал

тэсрэх  
материал

сэлбэг  
хэрэгсэл

хангамжийн  
материал

590.0

8.0

9.6

843.3

333.6

111.0

817.1

26.3

19.3

523.1

262.3

59.0

Тайлант онд Хөвсгөл, Завхан аймгийн 60 гаруй байгууллага аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж 100.0 мянган тн нүүрсийг борлуулсан. Үүнээс Эрчим хүчний нүүрс 41.4 мянган тн, коксжих нүүрс 58.6 мянган тн нүүрс тус тус борлуулсанаас Хөвсгөл аймагт 40.0 мянган тонн /дулааны станц 15.5 мянган тн/, Завхан аймагт 28.9 мянган тн, экспортонд 31.1 мянган тн нүүрсийг тус тус нийлүүлсэн байна. /Нийт борлуулсан коксжих нүүрснээс 27.5 мянган тн орон нутагт, 31.1 экспорт/

### Нүүрс хэрэглэгч аймгуудийн худалдан авсан нүүрсийг өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт




## **Үйлдвэрийн төлөвлөгөөт зорилтын биелэлтийн талаар**

2021 онд 1.0 сая.м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил хийж, 115.0 мянган тн нүүрс олборлон борлуулах зорилт тавин ажиллаж, 810.2 мянган м<sup>3</sup> хөрс хуулалтын ажил хийж 100.0 мянган тн нүүрс борлуулсан байна.


Тайлант хугацаанд нүүрсний борлуулалтын төлөвлөгөө 87 хувиар биелж, урд онтой харьцуулахад 37.2 мянган тн буюу 59.2 хувиар давуулан биелүүлсэн байна. 2021 онд 5179750.0 мянган төгрөгийн борлуулалт хийж, 4693439.0 мянган төгрөгийн зардал гарган, 486311.0 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс 4743101.7 мянган төгрөгийн борлуулалт хийж, 3858616.6 мянган төгрөгийн зардал гарган 796036.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

# Төлөвлөгөөт зорилтын биелэлтийг өмнөх оны үзүүлэлтүүдтэй харьцуулбал



## Хөрөнгө санхүүгийн талаар:

Тайлант онд компанийн нийт хөрөнгө 6719541.1 мянган төгрөг байгаа бөгөөд урд оноос 511648.8 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт хөрөнгийг дотор нь задалбал: дансан дахь мөнгө 1033161.3 мянган төгрөг, урд оноос 886889.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, нийт авлага 148401.8 мянган төгрөг, урд оноос 51.2 хувиар буурсан, бараа түүхий эд материал урьдчилж гарсан зардал 3915695.2 мянган төгрөг, урд оноос 1.3 хувиар өссөн, бусад эргэлтийн хөрөнгө 27055.8 мянган төгрөг, урд оноос 9.2 хувиар өссөн байна. Авлагаа задалж харуулбал нийт авлагын 90 хувийг Дулааны станцаас авах 141.0 сая төгрөгийн нүүрсний үнэ эзэлж байна.



## **Өр төлбөр эзэмшигчийн өмчийн талаар**

Өр төлбөр эзэмшигчийн өмчийн дүн 6719541.1 мянган төгрөг байгаагийн 1355756.2 мянган төгрөг нь богино хугацаат өр төлбөр бөгөөд урд оноос 16.7 хувиар өссөн. Богино хугацаат өр төлбөрт дансны өглөг 60834.6 мянган төгрөг, урьдчилж орсон орлого 886375.9 мянган төгрөг, татварын өглөг 406422.4 мянган төгрөг, бусад богино хугацаат өр төлбөр 2123.2 мянган төгрөг байна. Урт хугацаат өр төлбөр 793231.0 мянган төгрөг, эздийн өмчийн дүн 4570553.9 мянган төгрөг байгаа нь тайлант оны цэвэр ашиг 796036.7 мянган төгрөг.

## 2021 онд Байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажил:

| №  | Материалын нэр   | Хэмжих нэгж | Тоо/ш | Нийт үнэ<br>Мян.төг |
|--|--|-------------|-------|---------------------|
| 1  | Дүйцүүлэн хамгаалалт ногоон тэжээл тарих   | ш           | 2тонн | 2700.0              |
| 2  | 9га газрын хашааны тор   | ш           | 15    | 2227.5              |
| 3  | Газар хагалуулж үрээр тарилт хийсэн хөлс   | га          | 9     | 2250.0              |
| <b>Тарилтын зардал : 7177.5 мян.төгрөг</b> |  |             |       |                     |
| 4  | Сөрөг нөөлөл бууруулах, тоос тоосонцорыг дарах зорилгоор зам усалгаанд гарсан зардал   |             |       | 3755.6              |
| 5  | 2021 онд Мод үржүүлгийн газарт таригдсан мод, Аймгийн засаг даргын ногоо суварга босгоё аяны хүрээнд хийгдсэн мод тарилтын ажлын зардал. |             |       | 7270.0              |
| <b>Нийт зардал : 18203.1мян.төг</b>        |  |             |       |                     |

## 2021 оны БОМТ-ний хэрэгжилтэнд гарсан нийт зардлыг хүснэгтээр харуулбал:

| № | Ажлын нэр  | Зардал<br>/мянга.төг/ |
|---|--|-----------------------|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө     | 2900.0                |
| 2 | Нөхөн сэргээлтийн менежментийн арга хэмжээний төлөвлөгөө | 3580.0                |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах ногоон байгууламжинд                 | 2300.0                |
| 5 | Удирдлага зохион байгуулалт                              | 500.0                 |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө                  | 1920.0                |
| 7 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр                       | 1500.0                |
|   | Нийт зардал :12700.0 мян.төг                             |                       |



**Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийн ажлын үр дүн (10 га талбайд,  
2021.08.02)**



Уурхайн 2021 оны биологийн нөхөн сэргээлтийн ажил болон АЗД-ын  
“Ногоон суварга босгоё” аяны хүрээнд мод үржүүлгийн талбайд 3  
төрлийн 500 орчим мод тарив




## **Нийгмийн хариуцлагын талаар**

-Тус компани тайлант хугацаанд улс, орон нутгийн төсөвт 1180494.0 мянган төгрөгийн татвар шимтгэл төлсөн байна. Нийт татвар шимтгэлийг задалж харьцуулбал: НӨАТ-т 474310.2 мянган төгрөг, ашигт малтмалын нөөцийн төлбөрт 116781.5 мянган төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн татварт 8447.3 мянган төгрөг, ХАОАТ-т 75500.0 мянган төгрөг, бусад 5364.0 татварт мянган төгрөг Агаарын бохирдлын татвар 135809.9 мянган төгрөг, ААНОАТ-т 98594.3 мянган төгрөг, ЭМНД-ын шимтгэлд 265686.6 мянган төгрөг байна. Тайлант онд төлсөн татвар хураамжийг урд онтой харьцуулахад 2 дахин өссөн байна.

-Цэцэрлэг сумтай амтран ажиллах гэрээний хүрээнд сумын 2-р багийн Хаснагтийн давааны зам засварын ажилд техник тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлж ажилласан.

# Татвар хураамжийг өмнөх онтой харьцуулбал




-Цэцэрлэг сумын иргэдийн нүүрсний хөнгөлөлтөнд 230.4 тн нүүрс буюу 12189.1 мянган төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлэв.

-Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хийсэн хамтын гэрээг үндэслэн ажилчдын нийгмийн асуудлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: Компанийн өндөр настангуудад дэмжлэг 4470.0 мянган төгрөг, ажилчдын өвлийн түлшний хэрэгцээнд нүүрсийг 50 хувь хөнгөлж 9264.5 мянган төгрөг, уй гашуу тохиолдсон 1 ажилтанд 4700.0 мянган төгрөг, орон сууц барихад дэмжлэг үзүүлж 1800.0 мянган төгрөг, байгууллагын 1 өндөр настан таалал төгссөн тул 1260.0 мянган төгрөг тус тус олгосон.

-Мөн уурхайчдын баяр, шинэ жил, хүүхдийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд 7000.0 төгрөг, байгууллагын тэргүүний ажилчдыг шагнаж урамшуулахад 2823.1 мянган төгрөг, өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ажилтанд 80904.0 мянган төгрөг, бусад хандив 1363.7 мянган төгрөг, буцалтгүй тусламж 1760.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна

# Хүндрэл бэрхшээлүүдийн талаар

- Өрмийн машины эвдрэлээс шалгаалж тэсэлгээний ажил хийх боломжгүй болсноор уулын ажил 30 орчим хоног зогссон
- Ковид-19 вирусын тархалтаас шалтгаалж уурайн ажил 7 хоног зогссон
- Төлөвлөсөн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын ажил хийж чадаагүйн улмаас уулын ажил доголдож сул зогсолтууд ихээхэн гарсан
- Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас тэсрэх материал болон түлшний нөөцийг бүрдүүлэх боломжгүй болсноор 10 орчим хоног уулын ажил доголдож бүрэн хүчин чадлаар ажиллах боломжгүй болсон
- Хөрөнгө санхүүгийн нөөцгүй болсноор түлшний нөөц бүрдүүлэх боломжгүй болж хөрс хуулалтын дизель экскаваторыг зогсоож зөвхөн цахилгаан экскаваторыг ажиллуулснаар бүтээл буурч хугацаа алдсан тохиолдолууд бий болсон



*Анхаарал хандуулсанд  
баярлалаа*